



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2021 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл: 2,908.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,531.7 тэрбум төгрөгөөр, төлөвлөснөөс 1,092.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Төсвийн орлогын хувьд: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 12,689.4 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 34.1 хувь буюу 3,225.5 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 486.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 104.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 486.8 тэрбум төгрөгөөр давж биелэхэд татварын орлого 5.4 хувь буюу 580.0 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн нь нөлөөлжээ.
- Тайлант хугацаанд орлогын алба татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өргтийн албан татварын орлого, тусгай зориулалтын болон гадаад үйл ажиллагааны орлого төлөвлөснөөс давж биелсэн бол бусад татварын орлого гүйцэтгэл 5.9-9.4 хүртэлх хувиар төлөвлөснөөс дутуу биелжээ.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 93.3 тэрбум төгрөгөөр дутуу биелснээр 93.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь хувьцааны ногдол ашиг, төсөвт байгууллагын өөрийн орлого, газрын тосны орлого төлөвлөсөнд хүрч биелээгүйтэй холбоотой байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15,598.1 тэрбум төгрөгт хүрч 605.7 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 96.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 3.7 хувиар дутуу зарцуулагдсан ч өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар буюу 1,693.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх тесөл, арга хэмжээ 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 92.5 хувийн гүйцэтгэлтэй гарч 1,311.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон бол концессын эргэн төлөлтөд 266.2 тэрбум төгрөг зарцуулагдаж 99.99 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Зээлийн үйлчилгээний төлбөрийг өнгөрсөн оны мөн үеэс 11.9 хувь буюу 111.5 тэрбум төгрөгөөр буурсан бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 14.8 хувь буюу 143.9 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2021 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,908.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусlamжийн дүн 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12,689.4 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдхөн цэвэр зээлийн хэмжээ 15,598.1 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,908.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,531.7 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дунгээс 1,092.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 18.6 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол орон нутгийн төсвийн орлого 104.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн орлого 306.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 50.8 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 34.1 хувь буюу 3,225.5 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 12.2 хувь буюу 1,693.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төсвийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 21.9 пунктээр их гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,531.7 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	00-ны мөн үед	2021 оны урьдчилсан гүйцэтгэл				Тэрбум төгрөгөөр
		Төл.	Гүйц.	Хувь.	Зөрүү.	
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,868.40	427	2,159.30	505.7	1,732.30	
Засгийн газрын бонд	-249.4	2,258.60	-577.3	-25.6	-2,835.90	
Засгийн газрын зээл	2,661.40	697.4	593.3	85.1	-104.1	
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Тогтвортжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	138.8	612.8	728.8	118.9	116	
Өмч хувьчлал	21.2	5.4	4.7	87.0	-0.7	
НИЙТ ДҮН	4,440.40	4,001.20	2,908.80	72.7	-1,092.50	

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 732.8 тэрбум төгрөг төлсөн бол урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 216.0 тэрбум төгрөг, гадаад бондын үндсэн төлбөрт 3,163.4 тэрбум төгрөг тус тус төлөгдсөн байна. Засгийн газар урт болон богино хугацаат дотоод бонд шинээр гаргаагүй бол 2,802.1 тэрбум төгрөгийн урт хугацаат гадаад бонд шинээр гаргасан байна. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлийн байдлаар 1,041.1 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл, 285.0 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл авсан байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 12,689.4 тэрбум төгрөг болж, онгөрсон оны мөн үеэс 34.1 хувь буюу 3,225.5 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацааны орлогын төвлөгөө 4.0 хувь буюу 486.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 5.3 хувь буюу 50.8 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 12.8 хувь буюу 306.5 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 2.9 хувь буюу 104.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн бол улсын төсөв 0.2 хувь буюу 18.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дутуу төвлөрчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 0.2 хувь буюу 18.6 тэрбум төгрөгөөр буурсан бол орон нутгийн төсвийн орлого 2.9 хувь буюу 104.1 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлого 12.8 хувь буюу 306.5 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 5.3 хувь буюу 50.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлогын 2021 оны урьдчилсан гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,767.0	10,639.1	3,573.8	3,677.9	2,398.7	2,705.2	951.3	1,002.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	1,062.4	937.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	612.8	627.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,091.8	9,073.2	3,573.8	3,677.9	2,398.7	2,705.2	951.3	1,002.0
Татварын орлого	7,254.2	7,362.8	1,546.3	1,640.8	1,803.7	2,110.3	951.3	1,002.0
Орлогын албан татвар	2,010.9	2,211.7	1,027.5	1,105.5	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	1,803.7	2,110.3	951.3	1,002.0
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	176.1	199.6	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,804.0	2,837.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	879.2	827.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	15.0	16.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	935.0	943.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	610.1	527.3	342.6	335.7	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	1,837.6	1,710.4	2,027.6	2,037.1	595.0	595.0	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	1,137.5	1,007.0	230.7	262.2	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	1.4	1.5	0.0	0.0	0.0	0.0
Тусlamжийн орлого	171.3	176.5	10.4	7.5	595.0	595.0	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	528.8	526.8	1,785.1	1,765.9	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 88.8 хувийг татварын орлого, 11.2 хувийг татварын бус орлого эзэлж байна.

“


Татварын орлого 11,262.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 5.4 хувь буюу 580.0 тэрбум төгрөгөөр давж төвлөрчээ.

”

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 32.3 хувь буюу 2,751.2 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 49.8 хувь буюу 474.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Татварын орлогын 29.5 хувийг орлогын албан татвар, 20.1 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.8 хувийг хөрөнгийн албан татвар, 25.2 хувийг нэмэгдсэн өргтийн албан татвар, 7.3 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 8.4 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 7.7 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 5.4 хувь буюу 580.0 тэрбум төгрөгөөр давж биелэхэд орлогын албан татвар 0.1 хувь (278.8 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 20.0 хувь (376.9 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 13.3 хувь (23.4 тэрбум төгрөг), нэмэгдсэн өргтийн албан татвар 1.2 хувиар (33.2 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 10.6 хувь (1.6 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 0.9 хувиар (8.0 тэрбум төгрөг) тус тус давж биелсэн нь нөлөөлжээ.

Төлөвлөгөөтэй харьцуулахад онцгой албан татвар 5.9 хувь (52.2 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр хураамжийн орлого 9.4 хувиар (89.7 тэрбум төгрөг) тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр татварын орлого 32.3 хувь буюу 2,751.2 тэрбум төгрөгөөр өсөхөд тусгай зориулалтын орлого 2.8 хувь (0.5 тэрбум төгрөг)-аар буурсан боловч орлогын албан татвар 48.9 хувь (1,089.9 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 42.4 хувь (673.1 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 28.9 хувь (44.7 тэрбум төгрөг), нэмэгдсэн өргтийн албан татвар 28.4 хувь (628.2 тэрбум төгрөг), онцгой албан татвар 6.4 хувь (50.1 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 27.3 хувь (202.3 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 7.9 хувь (63.3 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.


“

Татварын бус орлого 1,426.6 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 474.4 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 93.3 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар дутшуу биелжээ.

”

Төлөвлөгөөтэй харьцуулахад төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.1 тэрбум төгрөг, гадаад хандив тусlamжийн орлого 5.5 тэрбум төгрөгөөр илүү төвлөрчээ. Харин нийтлэг татварын бус орлогоос төсөвт байгууллагын өөрийн орлого 108.6 тэрбум төгрөг, хувьцааны ногдол ашиг 26.2 тэрбум төгрөг, газрын тосны орлого 15.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн ч, торгуулийн орлого 33.1 тэрбум төгрөгөөр, бусад орлого 12.8 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 3.5 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 1.5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц / Хувиар/



Татварын бус орлогын 89.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 10.9 хувийг тусlamжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 2.3 хувийг хувьцааны ногдол ашиг, 5.5 хувийг хүүгийн орлого, 8.5 хувийг торгуулийн орлого, 21.9 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.4 хувийг түрээсийн орлого, 15.6 хувийг газрын тосны орлого, 7.3 хувийг навигацийн орлого эзэлсэн бол 36.1 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

“

Татварын ерөнхий газар төлөвлөгөөг 1.4 хувиар, Гаалийн ерөнхий газар 1.5 хувиар тус тус дутшуу биелүүлсэн үзүүлэлтийй байна.

”

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн дагуу нийт **18 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 9 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн** бол үлдсэн 9 нь 1.2-57.5 хувиар дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 3. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	Ө0-ны мөн үеийн	2021 оны урьдчилсан гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Сангийн сайд	7,368,356.1	9,747,939.7	9,630,726.5	-117,213.2	98.8
Татварын ерөнхий газар	4,196,137.7	5,556,920.3	5,478,582.5	-78,337.8	98.6
Үүнээс: Тогтвортжуулалтын санд	66,242.9	612,800.0	627,922.2	15,122.2	102.5
Ирээдүйн өв санд	753,878.6	872,430.0	733,114.5	-139,315.5	84.0
Гаалийн ерөнхий газар	2,891,865.0	3,560,230.0	3,507,938.3	-52,291.7	98.5
Сангийн яам	136,456.4	476,252.0	481,617.4	5,365.4	101.1
Гадаад тусlamжийн орлогоос санхүүжих	138,980.8	150,300.2	155,845.0	5,544.8	103.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,916.2	4,237.1	6,743.3	2,506.2	159.1

Монгол Улсын Их Хурлын дарга	127.6	100.0	90.8	-9.2	90.8
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	127.6	100.0	90.8	-9.2	90.8
Монгол Улсын Ерөнхий сайд	174,579.1	186,097.7	214,106.4	28,008.7	115.1
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	173,467.0	184,600.0	212,609.8	28,009.8	115.2
Үүнээс: Ирээдүйн өв санд	160,206.9	155,000.0	204,821.2	49,821.2	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,112.1	1,497.7	1,496.6	-1.1	99.9
Монгол Улсын Шадар сайд	15,029.6	13,049.1	15,437.1	2,388.0	118.3
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	3,591.3	3,900.0	2,924.4	-975.6	75.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	11,438.3	9,149.1	12,512.7	3,363.6	136.8
Хууль зүй, дотоод хэргийн сайд	46,617.4	55,778.0	53,418.7	-2,359.2	95.8
Улсын бүртгэлийн ерөнхий газар	11,583.0	17,000.0	16,105.0	-895.0	94.7
Цагдаагийн ерөнхий газар	1,345.4	5,000.0	2,030.0	-2,970.0	40.6
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	9,638.2	10,436.6	10,588.0	151.4	101.5
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	24,050.7	23,341.4	24,695.7	1,354.4	105.8
Гадаад харилцааны сайд	10,878.6	12,050.0	9,270.3	-2,779.7	76.9
Дипломат төлөөлөгчийн газрууд	10,672.8	10,500.0	9,227.4	-1,272.6	87.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	205.8	1,550.0	42.9	-1,507.1	2.8
Зам, тээврийн хөгжлийн сайд	83,871.0	148,108.4	133,140.3	-14,968.2	89.9
Иргэний нисэхийн ерөнхий газар	75,000.0	122,878.4	122,878.4	0.0	100.0
Зам, тээврийн хөгжлийн яам	223.0	230.0	230.0	0.0	100.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,648.0	25,000.0	10,031.8	-14,968.2	40.1
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	152,061.9	267,105.0	270,581.4	3,476.5	101.3
Ашигт малтмал, газрын тосны газар	150,281.8	265,400.0	268,876.5	3,476.5	101.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,780.1	1,705.0	1,705.0	0.0	100.0
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	97,699.6	105,884.4	116,949.6	11,065.2	110.5
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	104.8	605.6	392.2	-213.4	64.8
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	671.3	798.4	839.9	41.5	105.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	96,923.6	104,480.4	115,717.5	11,237.1	110.8
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	45,934.8	86,703.5	37,000.4	-49,703.0	42.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	45,934.8	86,703.5	37,000.4	-49,703.0	42.7
Эрүүл мэндийн сайд	25,189.1	4,741.0	4,329.9	-411.1	91.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	25,189.1	4,741.0	4,329.9	-411.1	91.3
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	701.7	295.5	1,568.1	1,272.6	530.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	701.7	295.5	1,568.1	1,272.6	530.7
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	5,895.5	8,113.2	9,024.9	911.7	111.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,895.5	8,113.2	9,024.9	911.7	111.2
Боловсрол, шинжлэх ухааны сайд	1,799.5	5,278.5	2,242.2	-3,036.2	42.5
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,799.5	5,278.5	2,242.2	-3,036.2	42.5
Барилга, хот байгуулалтын сайд	2,361.8	2,250.0	2,412.8	162.8	107.2
Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	2,361.8	2,100.0	2,412.8	312.8	114.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	150.0	0.0	-150.0	0.0
Батлан хамгаалахын сайд	44,223.7	50,541.0	52,532.8	1,991.8	103.9
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	4,025.0	9,699.1	9,252.4	-446.7	95.4
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	40,198.8	40,841.9	43,280.3	2,438.5	106.0
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	151.7	120.0	367.7	247.7	306.4
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	151.7	120.0	367.7	247.7	306.4
Санхүүгийн зохицуулалт хороо	1,805.6	1,709.1	1,845.3	136.2	108.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,805.6	1,709.1	1,845.3	136.2	108.0

Эх сурвалж: Сангийн яам

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахаад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,693.9 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар өсөж 15,598.1 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 16,203.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 96.3 хувийг зарлагадаж 605.7 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахаад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,693.9 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар өсөж 15,598.1 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын 2021 оны урьдчилсан гүйцэтгэл,

/төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

Зардлын зүйл	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,568.7	12,131.9	3,883.2	3,501.3	2,490.5	2,533.0	1,074.3	1,200.9
НИЙТ ЗАРЛАГА	12,927.5	12,315.9	3,845.6	3,483.7	2,594.3	2,562.7	1,210.7	1,208.1
ҮРСТАЛ ЗАРДАЛ	10,256.9	9,707.4	3,211.5	3,045.1	2,594.3	2,562.7	1,210.7	1,208.1
Бараа, ажил, үйлчилгээний зардал	2,785.4	2,597.5	2,377.8	2,259.5	26.4	25.6	49.9	47.5
Зээлийн үйлчилгээний төлбөр	965.5	821.6	6.0	6.0	0.0	0.0	0.0	0.0
Татаас	843.5	810.9	190.1	175.5	0.0	0.0	61.2	61.2
Урсгал шилжүүлэг	5,662.5	5,477.4	637.5	604.1	2,567.9	2,537.1	1,099.6	1,099.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,670.6	2,608.4	634.1	438.5	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-358.8	-183.9	37.6	17.7	-103.7	-29.7	-136.4	-7.2
НИЙТ ТЭНЦЭЛ	-3,476.9	-3,058.7	-309.4	176.6	-91.9	172.2	-123.0	-198.9

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 436.8 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 381.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан бол нийгмийн даатгалын сангийн зарлага 42.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 126.6 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 1,396.3 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 344.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 81.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 774.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 12.2 хувь буюу 1,693.9 тэрбум төгрөгөөр өсөхөд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 244.4 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 17.8 хувь буюу 1,925.5 тэрбум, хөрөнгийн зардал 0.4 хувь буюу 12.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахаад 11.9 хувь буюу 111.5 тэрбум төгрөгөөр буурч, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 14.8 хувь буюу 143.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан байна.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн
гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

	ӨО-ны мөн үе	2021 оны урьдчилсан гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА 6а ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,904.3	16,203.8	15,598.1	96.3	-605.7
НИЙТ ЗАРЛАГА	13,863.2	16,765.1	15,801.4	94.3	-963.8
УРСГАЛ ЗАРДАЛ	10,828.9	13,460.5	12,754.4	94.8	-706.1
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,851.2	4,955.6	4,660.1	94.0	-295.5
Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	2,648.9	2,592.7	2,528.5	97.5	-64.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	0.0	0.0	-	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	279.8	296.3	271.1	91.5	-25.2
Хангамж, бараа материалын зардал	172.3	195.4	187.5	96.0	-7.8
Нормативт зардал	354.3	273.7	262.3	0.0	-11.3
Эд хогшил, урсгал засварын зардал	124.2	129.0	118.7	92.0	-10.3
Томилолт, зочны зардал	16.5	25.6	19.9	77.4	-5.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	783.4	881.1	768.3	87.2	-112.7
Бараа үйлчилгээний бусад зардал	471.9	561.9	503.8	89.7	-58.1
XYY	939.2	971.5	827.7	85.2	-143.9
TATAAC	375.1	501.0	453.7	90.6	-47.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,663.5	7,032.4	6,813.0	96.9	-219.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	181.5	927.6	907.7	97.9	-19.9
Бусад урсгал шилжүүлэг	4,481.9	6,104.8	5,905.3	96.7	-199.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,034.2	3,304.7	3,047.0	92.2	-257.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	41.1	-561.3	-203.3	36.2	358.1

Эх сурвалж: Сангийн яам

“


Нэгдсэн төсвийн нийт зардалг урсгал зардлын эзлэх хувийн жин 81.8 хувьд хүрч, онгөрсон оны мөн үеэс 3.9 пунктээр нэмэгдсэн байна.

”

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 81.8 хувь буюу 12,754.4 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 53.4 хувийг урсгал шилжүүлэг, 36.5 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 6.5 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.6 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,925.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 191.1 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 111.5 тэрбум төгрөгөөр буурсан ч, татаас 78.6 тэрбум, урсгал шилжүүлэг 2,149.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

График 5. Урсгал зардлын бүтэц
/Хувиар/



“

Монгол Улсын 2021 оны төсвийн түхай хуулиар 32 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцууллах эрхийг баталсан бөгөөд 2021 оны үрьдчилсан гүйцэтгэлээр цэсийн төсвийн нийт зарлага 486.8 тэрбум төгрөгөөр дутчуу зарцуулагдаж 96.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

”

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 31.2 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 21.2 хувийг Сангийн сайдын багц, 13.9 хувийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц, 8.8 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 5.1 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, үлдэх 19.9 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал эзэлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч	2021 оны урьдчилсан гүйцэтгэл			
	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	13,177.8	11,996.0	1,181.8	91.0
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	61,907.4	60,371.6	1,535.8	97.5
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	169,474.6	163,746.7	5,727.9	96.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	95,553.3	71,110.0	24,443.3	74.4
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	100,950.2	82,616.0	18,334.2	81.8
САНГИЙН САЙД	2,659,625.9	2,568,283.7	91,342.2	96.6
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	278,959.4	276,935.7	2,023.8	99.3
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	1,079,237.3	1,061,864.2	17,373.2	98.4
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	2,666.9	2,666.9	0.0	100.0
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	5,227.7	4,151.6	1,076.1	79.4
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	61,161.3	60,044.3	1,117.1	98.2
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	72,879.2	67,673.2	5,206.0	92.9
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	5,943.0	5,930.5	12.4	99.8
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	26,878.0	24,176.6	2,701.4	89.9
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	10,382.2	10,224.5	157.6	98.5
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	7,102.8	5,590.3	1,512.5	78.7
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	2,769.6	2,424.0	345.6	87.5
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА	5,386.0	5,385.7	0.3	100.0
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	477,886.4	474,831.2	3,055.3	99.4
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	28,122.3	25,712.7	2,409.6	91.4
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	1,431.8	1,417.3	14.5	99.0
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	29,794.8	26,740.3	3,054.5	89.7
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	153,847.7	148,454.4	5,393.4	96.5
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	604,610.4	619,862.7	-15,252.3	102.5
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	217,879.2	207,098.6	10,780.7	95.1
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	1,711,610.6	1,681,670.1	29,940.6	98.3
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	297,486.1	268,202.0	29,284.1	90.2
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	39,755.7	36,253.6	3,502.1	91.2
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	193,833.0	174,183.5	19,649.5	89.9
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	67,693.7	65,975.8	1,717.9	97.5
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	3,947,398.2	3,784,761.6	162,636.7	95.9
СОЁЛЫН САЙД	138,089.0	131,555.2	6,533.7	95.3
НИЙТ ЗАРДАЛ	12,568,721.8	12,131,910.6	436,811.2	96.5

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,418.9 тэрбум төгрөг зарцуулхаа төлөвлөснөөс 1,311.8 тэрбум төгрөгийг зарцуулж 92.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2021 онд нийт 1,418.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс урьдчилсан гүйцэтгэлээр 1,311.8 тэрбум төгрөгийг зарцуулж 92.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл
/Төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Сая төгрөгөөр

Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	2021 оны төсөв	2021 оны урьдчилсан гүйцэтгэл			
			Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
I	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	1,066.6	1,066.6	1,064.5	2.1	99.8
II	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	3,570.3	3,570.3	3,431.7	138.6	96.1
III	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	151,128.8	32,830.4	32,121.0	701.8	97.8
IV	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	32,646.3	22,015.1	22,011.1	4.0	100.0
V	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	111,547.5	30,963.1	28,663.1	2,300.0	92.6
VI	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	31,998.0	18,045.0	16,814.0	1,231.0	93.2
VII	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	13,050.0	6,150.0	6,109.7	40.3	99.3
VIII	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	4,349.4	4,349.4	4,285.4	64.0	98.5
IX	САНГИЙН САЙД	289,936.5	88,186.3	54,825.2	33,361.2	62.2
X	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	69,098.3	29,157.0	28,854.4	302.6	99.0
XI	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	73,109.1	24,635.9	23,576.8	1,059.1	95.7
XII	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	425,047.0	193,290.3	182,801.2	10,489.1	94.6
XIII	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	887,783.2	361,831.5	337,278.7	24,552.7	93.2
XIV	СОЁЛЫН САЙД	548,984.5	92,839.1	89,725.3	3,113.8	96.6
XV	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	659,743.3	233,601.4	220,183.8	13,417.5	94.3
XVI	УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	3,696.9	1,727.1	1,674.8	52.3	97.0
XVII	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	50,365.4	21,122.4	20,017.0	1,105.3	94.8
XVIII	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	153,017.5	38,052.8	36,611.0	1,441.8	96.2
XIX	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	320,685.5	188,034.7	175,993.9	12,040.8	93.6
XX	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	1,150.0	1,150.0	1,141.1	8.9	99.2
XXI	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	4,000.0	4,000.0	3,697.4	302.6	92.4
XXII	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	43,517.8	20,312.9	19,951.9	361.0	98.2
XXIII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,497.3	1,497.3	636.2	861.1	42.5
XXIV	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	492.5	492.5	364.1	128.4	73.9
	НИЙТ	3,881,481.7	1,418,921.0	1,311,833.3	107,087.7	92.5

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд “Барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэх 266.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг санхүүжүүлэхээр төсөвлөснөөс урьдчилсан гүйцэтгэлээр 266.2 тэрбум төгрөгийг зарцуулж, 99.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 8. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж /Төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Сая төгрөгөөр


ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны урьдчилсан гүйцэтгэл				
	Төсөв	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	266,268.7	266,268.7	266,242.9	25.8	99.9
Төрийн худалдан авах ажиллагааны газар	266,268.7	266,268.7	266,242.9	25.8	99.9
Концессын төслийн эргэн төлөлт	266,268.7	266,268.7	266,242.9	25.8	99.9
I.Барилга байгууламж	266,268.7	266,268.7	266,242.9	25.8	99.9
Шилжих	134,879.1	134,879.1	134,853.3	25.8	99.9
“Чойр” дэд станцын өргөтгөл, шинэчлэлт	14,100.3	14,100.3	14,100.3	0.0	100.0
Төрөх эмнэлгийн барилгын дуусгал, дэд бүтэц, 300 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	30,778.8	30,778.8	30,753.0	25.8	99.9
Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хүчилттай авто зам төсөл	45,000.0	45,000.0	45,000.0	0.0	100.0
Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нэмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хүчилттай авто зам төсөл	45,000.0	45,000.0	45,000.0	0.0	100.0
Шинэ	131,389.6	131,389.6	131,389.6	0.0	100.0
Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хүчилттай авто зам төсөл /Баянхонгор/	131,389.6	131,389.6	131,389.6	0.0	100.0

Эх сурвалж: Сангийн яам

5. Нийгмийн даатгалын сан

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

ЗАРЛАГА

2,533.0 ↑ 3.3%

Тэргүүтэй
даатгалын сан



2,300.8

Тэргүүтэй
даатгалын сан



172.9

ҮОМШӨ-ний
даатгалын сан



305.8

Ажилгүйдлийн
даатгалын сан



57.8

Нийгмийн даатгалын сангийн орлого

2,398.7

Нийгмийн даатгалын сангийн зарлага

2,705.2

1,878.2

2,490.5

2,533.0

2,451.8

■ Төлөвлөө

□ Гүйцэтгэл (2021 оны 12 дугаар сар)

■ Өмнөх оны мөн үе


-Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үеэс)

Монгол Улсын 2021 оны урьдчилсан гүйцэтгэл

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын
Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 2,533.0 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 81.2 тэрбум төгрөг буюу 3.3 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 125.5 тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 24.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол ҮОМШӨ-ийн даатгалын сангийн зарлага 163.9 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 37.2 тэрбум төгрөгөөр буурчээ.


График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/



6. Эрүүл мэндийн даатгалын сан

“
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 5.3 хувиар давж биелжээ.
”


График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Эрүүл мэндийн даатгалын санд 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,002.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 5.3 хувь буюу 50.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

“
Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,200.9 тэрбум төгрөгийн зарлага хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 774.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.
”

График 8. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,074.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 1,200.9 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн гүйцэтгэл 111.8 хувтай гарчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сангийн нийт зарлага 774.5 тэрбум төгрөгөөр буюу 181.6 хувиар өссөн байна.

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 381.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

7. Орон нутгийн төсөв

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 3,677.9 тэрбум төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 2.9 хувь буюу 104.1 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 3,501.3 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 9.8 хувь буюу 381.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, **орон нутгийн төсвийн тэнцэл 176.6 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.**

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 16.9 хувиар буюу 531.1 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт зарлага 10.9 хувь буюу 344.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 52.0 хувийг орон нутгийн орлого, 36.9 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 4.9 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 6.2 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 179.2 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 228.3 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгохоор төлөвлөсөн нь тус бүр 100.0 хувийн гүйцэтгэлтэй биелсэн байна.

2021 онд 1,377.5 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг олгохоор төлөвлөснөөс урьдчилсан гүйцэтгэлээр 1,358.4 тэрбум төгрөг олгогдож 98.6 хувийн гүйцэтгэлтэй биелсэн байна.

График 9. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Хүснэгт 9. Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Сая төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	12,107.9	12,107.9	100.0	49,137.8	48,720.8	99.2	6,440.9	6,440.9	100.0
Баян-Өлгий	6,451.8	6,451.8	100.0	67,213.8	66,927.6	99.6	8,360.3	8,360.3	100.0
Баянхонгор	17,503.5	17,503.5	100.0	48,499.3	47,516.6	98.0	8,091.9	8,091.9	100.0
Булган	3,567.1	3,567.1	100.0	34,706.7	33,382.0	96.2	4,244.2	4,244.2	100.0
Говь-Алтай	13,993.8	13,993.8	100.0	40,404.0	39,773.1	98.4	10,079.4	10,079.4	100.0
Дорноговь	0.0	0.0	0.0	34,891.3	34,363.1	98.5	19,336.3	19,336.3	100.0

Дорнод	0.0	0.0	0.0	40,315.2	39,619.9	98.3	9,205.8	9,205.8	100.0
Дундговь	10,942.1	10,942.1	100.0	28,214.6	28,071.5	99.5	6,694.7	6,694.7	100.0
Завхан	17,469.1	17,469.1	100.0	46,323.7	45,525.1	98.3	5,987.6	5,987.6	100.0
Өвөрхангай	16,756.6	16,756.6	100.0	54,629.8	54,323.4	99.4	7,711.2	7,711.2	100.0
Өмнөговь	0.0	0.0	0.0	36,350.6	35,227.2	96.9	17,014.6	17,014.6	100.0
Сүхбаатар	8,917.9	8,917.9	100.0	32,473.6	32,200.8	99.2	16,679.2	16,679.2	100.0
Сэлэнгэ	5,226.1	5,226.1	100.0	54,627.4	53,201.9	97.4	10,341.5	10,341.5	100.0
Төв	9,670.9	9,670.9	100.0	49,338.4	47,199.1	95.7	9,333.7	9,333.7	100.0
Увс	14,010.3	14,010.3	100.0	49,449.5	48,515.5	98.1	7,535.4	7,535.4	100.0
Ховд	9,234.6	9,234.6	100.0	48,696.6	47,462.9	97.5	13,179.9	13,179.9	100.0
Хөвсгөл	18,661.5	18,661.5	100.0	72,672.6	71,903.1	98.9	9,641.3	9,641.3	100.0
Хэнтий	13,055.4	13,055.4	100.0	44,902.2	42,417.9	94.5	9,758.7	9,758.7	100.0
Дархан-Уул	0.0	0.0	0.0	39,789.5	39,518.7	99.3	8,676.2	8,676.2	100.0
Улаанбаатар	0.0	0.0	0.0	453,635.9	451,548.8	99.5	33,036.2	33,036.2	100.0
Орхон	0.0	0.0	0.0	42,181.0	42,013.2	99.6	5,353.7	5,353.7	100.0
Говьсүмбэр	1,613.2	1,613.2	100.0	9,039.3	9,020.1	99.8	1,558.1	1,558.1	100.0
ДҮН	179,181.6	179,181.6	100.0	1,377,492.7	1,358,452.1	98.6	228,260.8	228,260.8	100.0

Эх сурвалж: Сангийн яам

Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 104.1 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар илүү төвлөрсөн нь тусгай зориулалтын шилжүүлэг 1.4 хувь буюу 19.0 тэрбум төгрөгөөр дутуу шилжсэн ч орон нутгийн орлого 6.9 хувь буюу 123.1 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөнтэй холбоотой байна.

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг **Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 1,358.4 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгожээ.**

Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал: Дорноговь аймаг 6,887.5 сая, Өмнөговь аймаг 471.8 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлсэн бол Архангай аймаг 4,640.6 сая, Баян-Өлгий аймаг 1,240.7 сая, Баянхонгор аймаг 3,621.9 сая, Булган аймаг 5,662.9 сая, Говь-Алтай аймаг 1,478.8 сая, Дорнод аймаг 3,192.3 сая, Дундговь аймаг 2,460.0 сая, Завхан аймаг 4,712.8 сая, Өвөрхангай аймаг 5,942.0 сая, Сүхбаатар аймаг 4,080.8 сая, Сэлэнгэ аймаг 10,667.7 сая, Төв аймаг 8,840.7 сая, Увс аймаг 1,789.3 сая, Ховд аймаг 1,515.5 сая, Хөвсгөл аймаг 5,486.0 сая, Хэнтий аймаг 7,749.5 сая, Дархан-Уул аймаг 3,616.6 сая, Говьсүмбэр аймаг 3,546.2 сая, Орхон аймаг 11,581.1 сая, Улаанбаатар хот 19,617.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.